



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 08 сарын 31 өдөр

Дугаар А/329

Чингис хот

Бруцеллэз өвчнөөс сэргийлэх  
дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "а", 29.1.6-ын "а", 29.2, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5, 6.6, 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8, 9.9 дэх заалт, Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2020 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн А/182 тоот тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Малаас хүнд халдварладаг архаг халдварт бруцеллэз өвчнөөс сэргийлэх зорилгоор 2020 онд шинээр гарсан зөвхөн охин тугал, хурга, ишгийг зааврын дагуу дархлаажуулах ажлыг 08 дугаар сарын 01-ний өдрөөс 09 дүгээр сарын 01-ийг хүртэл хугацаанд чанартай хийж гүйцэтгэхийг Мал эмнэлгийн тасгийн дарга, Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн захирал, малын эмч нарт даалгасугай.

2. Дархлаажуулалтын ажлын хэсэгт Мал эмнэлгийн тасгийн мэргэжилтэн, багийн Засаг дарга, төрийн албан хаагчдыг томилон ажиллуулж, технологит хугацаанд нь үр дүнтэй зохион байгуулахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад шаардлагатай вакцин, мэргэжил арга зүйн заавар зөвлөмжөөр хангаж, ажлын явц, чанар, гүйцэтгэлд хяналт тавих, дархлаажуулалтын дүнг танилцуулах, санхүүжилтийн баримт материалыг холбогдох яаманд хүргүүлэх ажлыг Мал эмнэлгийн газар /Н.Анхбаяр/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА